



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2026 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/02

Дадал сум

Албан тушаалын тодорхойлолтыг
шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Боловсролын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Сургуулийн Өмнөх болон Ерөнхий Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1.11, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Төрийн албаны Зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2, 3.7, 3.8, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Боловсролын сургалтын байгууллага төрийн болон орон нутгийн өмчийн хэлбэртэй хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтыг албажуулж, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх, тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг хүний нөөцийн асуудал хариуцсан цэцэрлэгийн аргазүйч (О.Урансайхан)-д үүрэг болгосугай.

3. Цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/12 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг хүчингүйд тооцсугай.

ЭРХЛЭГЧ



Н.ОДГАРАВ

1825020053 9075909